

# ХҮҮХДИЙН ЦАГААН ХОРХОЙТОХ ӨВЧИН /ЭНТЕРОБИОЗ /

ЭМГ-ын ХТҮХМэргэжилтэн П.Хишгээ

# ХҮҮХДИЙН ЦАГААН ХОРХОЙТОХ ӨВЧИН

- Хялгасан хорхойн өвчин нь *Enterobius Vermicularis* үүсгэгчээр үүсдэг дэлхий дахинд өргөн тархсан шимэгч хорхойн шалтгаант өвчин юм. Олон нийтийн дунд цагаан хорхойн өвчин, цагаан хорхойн шижнилгээ өгөх зэрэг нэршил тархсан байдаг.
- Шимэгч хорхой нь 0,7-1,3 см урттай, цагаан өнгөтэй, тахиралдсан хэлбэртэй, бичгийн үдээсний хэмжээтэй, цайвар шаргал өнгөтэй
- Анхдагч халдвар нь 2 хоног хэртэй үргэлжлэх ба хурц үе нь 5-7 хоног байх нь тохиолдоно.
- Далд үе нь цагаан хорхойн өндөг ялгарахаас эхлэн 35 – 70 хоног үргэлжилж болно.



# ХАЛДВАРЛАХ ЗАМ

- Хялгасан хорхой өвчний байгалийн эзэн бие нь зөвхөн хүн юм.
- Хүнээс хүнд дамжин халдварладаг.Хялгасан хорхой нь бүхий л нийгмийн орчинд халдварлах боломжтой. Ялангуяа бүл үүсгэн нэгэн дор нягтран амьдардаг орчин болон гэр бүлийн гишүүдийн дунд өргөн тархсан байдаг.
- Бүх насныхан өвчлөх эрсдэлтэй,цэцэрлэг,сургуулийн насны /5-10 нас/ хүүхдүүдийн дунд өргөн тархсан байдаг,
- *Enterobius Vermicularis*-н амьдралын мөчлөг маш энгийн.Бие гүйцсэн эм хорхой хошногоны амсрын эргэн тойрны арьсны нугалаасанд өндгөө гаргаснаар амьдралын мөчлөг нь эхэлнэ. Энэ үед хошноого загатнах ба хошноогоо маажиж халдвартай өндгөөр гар нь бохирлогдон аутоинфекци буюу өөрөө өөртөө халдвар дамжуулах үүд болдог.
- Өндгөөр бохирлогдсон гараар хоол унд, хувцас,цагаан хэрэглэлд хүрснээр хүнээс хүнд халдвар дамжина. Үүнээс гадна өндөг агаар дусал, амьсгалын замаар дамжих эрсдэлтэй
- Мөн хуруугаа хөхдөг, амандаа байнга гараа хийдэг, хумсаа мэрдэг хүүхдүүд *Enterobius Vermicularis* шимэгчийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй

## АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ

- Хоол боловсруулах замд орсны дараа өндөг хагарч нарийн гэдсэнд авгалдай чөлөөлөгдөнө. Бие гүйцсэн хорхойнууд ходоод гэдэсний замд, ялангуяа мухар гэдэс, мухар олгойд ихээр байрлана.
- Хоол боловсруулах замаар ороод халдвартай өндгөөс бие гүйцсэн хорхой болж хөгжихөд ойролцоогоор нэг сарын хугацаа зарцуулагддаг.
- Бие гүйцсэн эм эм хорхой бүр 10,000 ба түүнээс дээш өндөг гаргах чадвартай. Бие гүйцсэн хорхойн амьдрах хугацаа 2-3 сар.
- Халдвартай хүмүүсийн гэдсэнд бие гүйцсэн хэдэн зуун хорхой амьдарч тухайн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг байна.
- Үр тогтсон эм хорхой шулуун гэдэснээс хошногоны нүх ормын арьсанд нүүдэллэн очиж өндгөө гаргана. Энэ үйл явц нь ихэнхдээ шөнийн цагаар тохиолдоно. Өндгөн доторхи авгалдай ерөнхийдөө 4-6 цагийн дараа бие гүйцэж, халдвартай өндөгт хувирна.
- Өндөгнүүд халуун хуурай орчинд 1-2 өдрийн дотор идэвхээ алддагч сэрүүн чийглэг орчинд 2 долоо хоногоос ч илүү хугацаагаар амьдрах чадвартай

## ЭМНЭЛЗҮЙН ШИНЖҮҮД

- Хошногоны амсар орчим загатнах
- Нойр муудах
- Хошногоны амсар орчим маажсанаас үүдэлтэй шархлаа үүсэж, хоёрдогчоор бактерийн халдварт өртөх /анусны амсарын үрэвсэл, анус орчмын зөөлөн эдийн үрэвсэл/
- Хэвлийгээр өвдөх, дотор муухайрах, бөөлжих
- Охидод үтрээний үрэвсэл /Вульвовагинит/, сальфингит, офорит, гялтан хальсны үрэвсэл
- Хүүхдийн бие организм харшламтгай болох
- Шимэгч хорхойтох өвчнөөр удаан өвдсөнөөс хүүхэд хоолонд дургүй болох, турах шинж илэрнэ

# ОНОШИЛГОО

- Цагаан хорхойн шинжилгээ өгөх. Хэд хэдэн удаа шинжилгээ өгөх нь чухал (2-4 удаа давтан) өгөх!
- Шимэгч хорхойг “**Наалдуулдаг савх**” ашиглан оношилно. Уг савхыг модоор хийсэн, орой хэсэгт хөвөн бамбар бэхэлсэн байна.
- Шинжилгээ авахдаа хөвөн бамбараар хоншногоны амсар орчмын арьсыг нэг чигт арчин өндгийг бамбартаа наалдуулж авна. Эдгээр өндгийг тавиур шилэнд түрхэж, микроскопоор харна./ өндөг нь 50-25 микрон хэлбэртэй, тэгш бус хавтгай вандуй төст хэлбэртэй /
- Шинжилгээг шөнө эсвэл өглөө эрт авахад илүү үр дүнтэй .
- Эмэгчин хорхой ч хошногоны амсар орчим тохиолдож болно. Цагаан өнгөтэй, шөвгөрдүү, 8-13 мм орчим урттай байна. /Баасыг шинжлэх нь учир дутагдалтай, хялгасан хорхой, түүний өндөг нь ихэнхдээ баасаар гадагшилдаггүй байна.

## ЭМЧИЛГЭЭ

- Гэдэсний шимэгчийн эсрэг эмчилгээ:Эмчид үзүүлж тохирсон эмийг тохирсон тунгаар уулгах /хүүхдэд /
- Альбендазол /400 мг/ эсвэл Мебендазол /100мг-аар 1 удаа уугаад 2 долоо хоногийн дараа тунг давтана /
- Шимэгчийн эсрэг эмийн нэг удаагийн тунг хэрэглэхэд эмчилгээний өндөр идэвхтэй боловч 2 долоо хоногийн дараа тунг давтах нь эмчилгээ 100% үр дүнд хүрэхээс гадна халдварын дахилтаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой



# УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ



- Гарын ариун цэврийг сайтар сахих, гараа зөв угаах дадал хэвшилд сургах, гарын хумсыг дор дор нь авах
- Ариун цэврийн өрөөнд орсны дараа гараа угааж хэвших
- Хумсаа мэрэхгүй байх
- Хоол хүнсийг сайтар жигнэж, болгож идэх, жимс жимсгэнийг сайтар угааж, хальсыг нь авч идэх
- Ор дэрний даавуу, хүүхдийн хувцас, хүүхдийн тоглоом бохирлогдсон эд зүйлсийг цэвэрлэх үед сэгсэргүйгээр хумиж авах
- Ор дэрний даавуу, унтлагын хувцас, хөнжил гудас зэргийг нарны цацрагт дэлгэж тавих
- Дотуур болон унтлагын хувцас, ор хөнжлийн даавууны ариун цэврийг сахих, заавал индүүдэх
- Шимэгчийн өндөг нь наалдамхай чанар ихтэй, гэрийн хивс, шал, ор дэр, хүүхдийн тоглоомонд ихээр наалддаг сайтар цэвэрлэгээ хийх
- Гэрийн тэжээвэр амьтдыг 3 сар тутамд малын эмчид үзүүлж байх
- Жилд нэг удаа эмчид хандаж, шинжилгээ өгч байх





**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА**